



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 08 өдөр

Дугаар A/155

Мандалговь


Г Гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны A/93 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжигдэх "Сайнцагаан сумын төвийн Хүүхдийн паркаас МТ шатахуун түгээх станц хүртэл гадна гэрэтийн" ажлын гүйцэтгэгчээр "Эрчим сансар" ХХК-ийг сонгон 176,411,651 /нэг зуун далан зургаан сая дөрвөн зуун арван нэгэн мянга зургаан зуун тавин нэг/ төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Эрчим сансар" ХХК – ний захиралд үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/, Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/ нарт тус тус үүрэг болгосугай.



ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

0300478